



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

Г Хорооны 2011 оны 366 дугаар тогтоолыг Г
хүчингүй болсонд тооцох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.3, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар Төсвийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн “Сүхбаатар аймгийн орон нутгийн бондыг бүртгэх тухай” 366 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

2. Хорооны 2011 оны 366 дугаар тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан Сүхбаатар аймгаас нийтэд санал болгон гаргахаар үнэт цаасны бүртгэлд бүртгүүлсэн 12 сарын хугацаатай, жилийн 12 хувийн хүүтэй, нэг бүр нь 100,000 /нэг зуун мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5,000 /таван мянга/ ширхэг, 18 сарын хугацаатай, жилийн 12.5 хувийн хүүтэй, нэг бүр нь 100,000 /нэг зуун мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 15,000 /арван таван мянга/ ширхэг нийт 2,000,000,000 /хоёр тэрбум/ төгрөгийн үнийн дүн бүхий 20,000 /хорин мянга/ ширхэг орон нутгийн бондыг бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар/Б.Саруул/-т үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар/Б.Саруул/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар/Д.Нямцэрэн/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН